

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 86/Я/400

Улаанбаатар хот

Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж,
шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 18.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 7, 8 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журмыг хавсралтаар баталсугай.
2. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, тайлагнаж байхыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Б.Лхагва), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал), Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Тамгын газрын дарга (Ч.Энхбат), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга (Ц.Тэрбиш)-д тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Я. Содбаатар
Я. СОДБААТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Т.МӨНХСАЙХАН

Монгол Улсын Шадар сайд,
Эрүүл мэндийн сайдын 2020 оны
08 сарын 12-ны өдрийн 86/19/400
дугаар хамтарсан тушаалын хавсралт

**Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж,
шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журам нь эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийж, зөрчлийг илрүүлэх, арилгах, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад оршино.

1.2. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрт дараахь баримт бичиг хамаарна:

- 1.2.1. Монгол Улсын хууль;
- 1.2.2. Улсын Их Хурлын тогтоол;
- 1.2.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр: зөвлөмж, хуралдааны тэмдэглэл;
- 1.2.4. Засгийн газрын тогтоол;
- 1.2.5. Төрөөс баримтлах бодлого;
- 1.2.6. Үндэсний хөтөлбөр;
- 1.2.7. Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр;
- 1.2.8. Сайд, агентлагийн даргын тушаал, шийдвэр.

1.3. Журам нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хэвлэл мэдээлэл болон нялх, балчир хүүхдийг хооллох зориулалтын бүтээгдэхүүнийг импортлогч, үйлдвэрлэгч, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээд, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудад хамаарна.

1.4. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын эхийн сүүг орлуулах бүтээгдэхүүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний олон улсын аргачлал, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу хийнэ.

Хоёр. Үнэлгээний хамрах хүрээ

2.1. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний хамрах хүрээнд дараахь чиглэл ороно:

2.1.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн зар сурталчилгаа (Телевиз/радио, сурталчилгааны самбар, зурагт хуудас, гарын авлага, ном, сэтгүүл, сонин, цахим сүлжээгээр зориулалтын бүтээгдэхүүний мэдээлэл, сурталчилгаа, цахим сурталчилгаа);

2.1.2. Худалдаа борлуулалт (зориулалтын бүтээгдэхүүний хямдралтай, хөнгөлөлттэй, тусгай урамшуулалт бөөний болон жижиглэн худалдаа явуулж байгаа

хүнсний зах, сүлжээ, супермаркет, дэлгүүр (бүх төрлийн), мухлаг, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, цахим худалдаа);

2.1.3. Эрүүл мэндийн байгууллага дахь сурталчилгаа (зориулалтын бүтээгдэхүүний загвар дээж, хэвлэмэл, сургалт, сурталчилгааны бүтээгдэхүүн, урамшуулал, бэлэг дурсгалын зүйлс, зөвхөн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан арга хэмжээ, мэдээлэл болон шинжлэх ухааны материал).

2.2. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд дараах байгууллагууд хамрагдана:

2.2.1. Хэвлэл, мэдээллийн суваг болон цахим сүлжээ (телевиз, радио, сурталчилгааны самбар, бусад; интернет: цахим хуудас, Фейсбук, Твиттер, Инстаграм, гар утасны applicейшн, бусад; хэвлэмэл материал: сэтгүүл, сонин, мэдээллийн хуудас, гарын авлага, бусад);

2.2.2. Худалдаа борлуулалтын газар (супермаркет, дэлгүүр, хүнсний зах, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, бусад);

2.2.3. Гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллага;

2.2.4. Эрүүл мэндийн байгууллага (төрийн болон хувийн хэвшлийн);

2.2.5. Олон нийтийн газар (цэцэрлэгт хүрээлэн, театр, кинотеатр, задгай талбай, бусад).

Гурав. Үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

3.1. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг жил бүр Эрүүл мэндийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж хяналт тавих эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.2. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг жилийн турш, тасралтгүй хийнэ.

3.3. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар орон нутагтаа хийж, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд тайлагнана.

3.4. Мэргэжлийн хяналтын байгууллага чиг үүргийнхээ хүрээнд баталсан журам, заавар, хяналтын хуудсын дагуу аймаг, нийслэлийн хэмжээнд хяналт хийнэ.

3.4.1. Мэргэжлийн хяналтын байгууллага нь нялхсын болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоол, нялх, балчир хүүхдийн эмчилгээний тусгай сүүн тэжээл, нялх, балчир хүүхдийн ундаа, хооллох хэрэгсэл (цаашид нялх, балчир хүүхдийг хооллох зориулалтын бүтээгдэхүүн гэх)-ийг импортлох, үйлдвэрлэх, худалдаалах үед чанар, аюулгүй байдал, сав, баглаа боодол, шошгололт, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, холбогдох мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ.

3.5. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь нялх, балчир хүүхдийг хооллох зориулалтын бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хяналт тавих, иргэд, хэрэглэгчид, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ.

3.6. Гаалийн өрөнхий газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын импортлосон нялх, балчир хүүхдийг хооллох зориулалтын бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээ, үйлдвэрлэсэн, импортлосон улс зэрэг мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ.

3.7. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх орон тооны бус Хүнсний сав, баглаа боодол, шошгын хяналтын зөвлөл нь нялх, балчир хүүхдийг хооллох зориулалтын бүтээгдэхүүний шошгын олгосон зөвшөөрлийн талаар тайлагнана.

Дөрөв. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналтын мэдээллийг тайлagnах хугацаа

4.1. Энэхүү журмын дагуу байгууллагууд холбогдох мэдээллийг боловсруулж, жил бүрийн нэгдүгээр сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлнэ.

4.2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь байгууллагуудын тайлан, мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тайланг Эрүүл мэндийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгжид жил бүрийн хоёрдугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ.

4.3. Эрүүл мэндийн яам нь хяналт, үнэлгээний тайлан, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд тайлагнана.

4.4. Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд тусгайлсан үнэлгээг үйл ажиллагааны удирдамжийн дагуу жил бүр салбар, чиглэлээр хийж, орон нутагт, тухайн байгууллага газар дээр нь үйл ажиллагаатай танилцаж, санал, зөвлөмж боловсруулна.

--- ooOoo ---